

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛААГААНЫ ТАЙЛАН

2022.06.10

Цэцэрлэг хот

Зорилго: Үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, сонирхлын зөрчилгүй ажиллах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, төсвийн болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зэрэг манлайллын зорилтуудыг хангах талаар төсвийн шууд захирагчийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино.

Үндсэн хэсэг:

1. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр

Иргэний бүртгэлийн тасаг нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Тэмдэгтийн хураамжын тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Архивын тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон эдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомж дүрэм журмыг өдөр дутаамын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.

1.1. Иргэний шинэчилсэн бүртгэл болон иргэний үнэмлэх олголтын талаар:

2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар **2000** гаруй иргэн шинэчилсэн бүртгэлд шинээр болон дахин бүртгүүлсэн, **651** иргэний үнэмлэхийг шинээр, **1169** иргэний үнэмлэхийг сунгалтаар, **118** иргэний үнэмлэхийг дахин хэвлүүлэн хүлээн авч иргэдэд олгосон байна.

Бүртгэлийн алдаатай болон иргэний үнэмлэх нь хэвлэгдээгүй, зөрчилтэй насанд хүрээгүй иргэдийн зөрчлийг түргэн, шуурхай арилгах зорилтын хүрээнд ХААТР-11 маягтаар **12** ширхэг, ХААТР-12 маягтаар **1** ширхэг, ХААТР-15 маягтаар **12** ширхэг, ХААТР-18 маягтаар **3** ширхэгийг нөхөн бүрдүүлэлтээр, засвар өөрчлөлтийн мэдэгдэх хуудсаар **126**, үг үсгийн алдаатай **430** ширхэг, санд хаяг оруулах **70** иргэний алдааг засуулхаар тус тус төвд хүргүүлэн ажиллаа.

Нийт **1938** иргэнд иргэний үнэмлэхийг хэвлэн олгосон, насанд хүрч шинээр авсан **651**, иргэний үнэмлэхээ гээгдүүлсэн болон дахин авсан **1287** иргэнд тус тус олгосон. Үүнээс E-Mongolia цахим үйлчилгээгээр **67** иргэн иргэний үнэмлэх дахин олголтоор захиалан авсан байна.

1176 иргэний үнэмлэхийг хүчингүй төлөвт шилжүүлэн дахин олгосон байна.

Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 4/2584 тоот чиглэлийн дагуу иргэний улсын ахлах бүртгэгч, архивч, 3 улсын бүртгэгч нарт хуваарь гарган:

а. 2020 онд иргэний үнэмлэхийн бүртгэлд анх удаа 1185, 25 нас хүрсэн иргэнд сольж олгосон 1081, 45 нас хүрсэн иргэнд сольж олгосон 1141, гадаадад 14, дахин олгосон 853, нийт **4274** ширхэг хэвлэгдэж ирсэн иргэний үнэмлэхийг

б. 2021 онд иргэний үнэмлэхийн бүртгэлд анх удаа 1260, 25 нас хүрсэн иргэнд сольж олгосон 1016, 45 нас хүрсэн иргэнд сольж олгосон 1158, гадаадад 18, дахин олгосон 419, нийт **3871** ширхэг хэвлэгдэж ирсэн иргэний үнэмлэхийг

в. 2022 онд иргэний үнэмлэхийн бүртгэлд анх удаа 387, 25 нас хүрсэн иргэнд сольж олгосон 317, 45 нас хүрсэн иргэнд сольж олгосон 382, гадаадад 4, дахин олгосон 84, нийт **1174** ширхэг хэвлэгдэж ирсэн нийт **9319** иргэний үнэмлэхийн бүртгэлийн цээж зургийг стандартын дагуу авсан эсэх, бүртгэл үнэн зөв эсэхийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэг бүрчлэн нягтлан шалгасан. Шалгах явцад зургийн болон бүртгэлийн зөрчилтэй иргэний үнэмлэх хэвлэгдээгүй байна. Тус албан тоотын дагуу биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл /ИУБ-31/ бүртгэхдээ иргэний цээж зургийг стандартын дагуу авах, бүртгэлийг үнэн зөв хөтлөх, алдаа гаргахгүй байхыг сумдын улсын бүртгэгч нарт үүрэг болгон ажилллаж байна.

1.2. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн талаар:

Сумдад бүртгэгдсэн ИУБ-11 маягтаар **652**, ИУБ-12 маягтаар **25**, ИУБ-13 маягтаар **43**, ИУБ-14 маягтаар **22**, ИУБ-15 маягтаар **126**, ИУБ-16 маягтаар **45**, ИУБ-18 маягтаар **258**, ИУБ-21 маягтаар **1676**, ИУБ-22 маягтаар **461**, ИУБ-25 маягтаар **10**, ИУБ-31 маягтаар **1938** нийт **5256** ширхэг бүртгэлийн ИУБ маягтуудыг шалгаж шивэлт хийн, баталгаажуулсан.

Иргэний гэр бүлийн байдлын 7 төрлийн бүртгэлийг сум тус бүрээр гаргавал:

д/д	Сумдын нэр	Төрөлт	Үрчлэлт	Овог, эцгийн нэр, нэр өөрчлөлт	Эцэг тогтоолт	Гэрлэлт	бүл Гэр цуцлалт	Нас баралт
1	Батцэнгэл	16	2	3	2	3		5
2	Булган	13	1			2		2
3	Жаргалант	6						3

4	Ихтамир	39	4	3	2	12	3	11
5	Өгийнуур	23				3		6
6	Өлзийт	19			1	7	1	14
7	Өндөр-Улаан	41	1	8	2	15	1	12
8	Тариат	23	1	3	2	6	2	12
9	Төвшрүүлэх	9		1		3		4
10	Хайрхан	23			1	5		9
11	Хангай	19				2	1	13
12	Хашаат	13			1	1		8
13	Хотонт	19			1	4		7
14	Цахир	29		1		5	1	11
15	Цэнхэр	50		1	4	6	3	20
16	Цэцэрлэг	32	5	1		4	1	11
17	Чулуут	13	1	2		8		11
18	Эрдэнэбулган	93	4	16	3	13	3	35
19	Эрдэнэмандал	36	4	2	1	10		22
20	Иргэний бүртгэл	136	2	2	2	17	8	42
Нийт		1698	652	25	43	22	126	24

Тус аймгийн 100-аас дээш настай 8 иргэний мэдээллийг нягтлан шалгаж Батцэнгэл сумын 1 иргэний нас баралтыг бүртгэж, 7 иргэний мэдээллийг сар шинийн баяраар хүндэтгэл үзүүлэх өндөр настануудын судалгааг ИУБГ-т хүргүүлсэн.

Хүүхдийн мөнгөн тэтгэмж нь эцэг, эхийн мэдээлэл суугдаагүй, хаяггүй шалтгаанаар орохгүй байгаа 70 хүүхдийн мэдээллийг нягтлан шалгаж 58 хүүхдийн мэдээллийг засвар өөрчлөлтөөр, 22 хүүхдийн мэдээллийг хяналтын байцаагчийн дүгнэлтээр тус тус алдааг залруулсан.

Хуульд зааснаар бүртгэлийн нотлох баримтыг дараа оны 02 дугаар сарын 15-ны дотор бүх сум нотлох баримтаа архивт хугацаанд нь ирүүлсэн.

2022 оны иргэний гэр бүлийн байдлын 7 төрлийн бүртгэлийн нотлох баримтыг тухай бүр шалган баталгаажуулж байгаа болно.

Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/134 тоот чиглэлийн дагуу 2022 оны 01 дүгээр сарын 03-аас эхлэн бүртгэсэн иргэний улсын бүх төрлийн бүртгэлийн **10780** эх нотлох баримт бичиг, ИУБ маягтуудыг цахимжуулсан. Цахимжуулсан тухай тоон мэдээг 5 удаа сарын мэдээгээр тайлагнан ажиллаа.

Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 4/522 тоот чиглэлийн дагуу эцэг, эхийн мэдээлэл зөрүүтэй, үг үсгийн алдаатай **181**

иргэний, засвар өөрчлөлтийн мэдэгдэх хуудсаар **29** иргэний, санд хаяг оруулах **22** хүүхдийн мэдээллийг албан тоот хүргүүлэн ажилласан.

2006 онд төрсөн 1831 хүүхдийн ХААТР-11 маягтыг нягтлан шалгаж, өөр аймаг, нийслэл рүү шилжин явсан 261, эцэг, эхийн мэдээлэл суугдаагүй 49, 58 хүүхдийн мэдээллийг засвар өөрчлөлтөөр, 22 хүүхдийн мэдээллийг хяналтын байцаагчийн дүгнэлтээр тус тус алдааг залруулсан.

1.3. Үндэсний энгийн гадаад паспорт олголтын талаар:

Тус хэлтсээр дамжуулан **315** иргэнд үндэсний энгийн гадаад паспортыг олгохоор захиалга хүлээн авсанаас, **202** иргэнд 10 жилийн хугацаагаар гадаад паспортыг хэвлүүлэн олгосон, **170** иргэний үндэсний энгийн гадаад паспортыг хүчингүй болгож, хүүхдийн хавсралт олголт хийгдээгүй байна.

Үүнээс E-Mongolia цахим үйлчилгээгээр **15** иргэн гадаад паспорт дахин олголтоор захиалан авсан байна.

1.4 Иргэн шилжин суурьших хөдөлгөөний талаар:

Тус аймагт **255** иргэн бүрмөсөн шилжин ирсэнээс **154** нь насанд хүрсэн иргэн, **101** нь хүүхэд бүртгэгдсэн байна.

Аймаг дотор сум хооронд **230** иргэн бүрмөсөн шилжин ирсэнээс **141** нь насанд хүрсэн иргэн, **89** нь хүүхэд, баг хооронд **289** иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэснээс **166** нь насанд хүрсэн иргэн, **123** хүүхэд шилжин суурьшжээ.

Шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлсэн боловч иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэл нь баталгаажаагүй иргэн байхгүй, алслагдсан сумаас ирж амжаагүй ИУБ-22 маягт байхгүй.

Бүх сумдаас шилжин явсан, шилжин ирсэн иргэдийн ИУБ-22 маягтыг ажлын 5 өдөрт багтааж санд шивж, баталгаажуулсан, өөр аймаг, нийслэлээс шилжин ирсэн иргэдийн хувийн хэргийг 21 хоногийн дотор татан авч архивт байршуулхаар албан тоотыг харъяа аймаг, нийслэл рүү хүргүүлэн ажиллаж байна.

Өөр аймаг, нийслэлээс албан тоотоор ирүүлсэн **403**, харъяалал харгалзахгүй бүртгэл хийлгэсэн иргэдийн **508**, нийт **911** иргэний хувийн хэргийг хүлээн авч архивт байршуулсан байна.

Өөр аймаг, нийслэл рүү харъяалал харгалзахгүй бүртгэл хийлгэсэн иргэдийн **129**, албан тоотоор **1440** иргэний хувийн хэргийн ХААТР, ИУБ маягтуудыг хүргүүлэн ажиллаа.

1. Сонгуулийн ажлын талаар:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам”, Аймаг,

нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг /нөхөн, дахин/ хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө,УБЕГ-аас өгсөн заавар, цахим чиглэлийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Өгийнуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 02 тоот тогтоолыг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр хүлээн авч, эх хувийг Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн.

Иргэний улсын ахлах бүртгэгчид хэсэг байгуулсан тогтоолыг шивэх эрх авсан ба хэсгийн нутаг дэвсгэр, санал авах байрны мэдээллийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолтой тулган шалгаж, санал авах байр буюу хэсгийн төв түүнд хамаарах хаягийн мэдээллийг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр мэдээллийн санд шивж, баталгаажуулсан. Баг хуваагдаагүй, тогтоолд тусгагдаагүй буюу орхигдсон хаяг байхгүй.

2. Өгийнуур сумын Орхон 4-р багт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй 407 сонгуулийн насны иргэнийг 1-6-5 хэсэгт бүрэн гүйцэд бүртгэсэн. Сонгуулийн эрх бүхий иргэний мэдээллийг давхардалгүй, үнэн зөв, бүрэн гүйцэд бүртгэсэн эсэхийг өдөр бүр нягтлан шалгаж ажилласан.

Тус хэсэгт 2021 оны 06 дугаар сарын 25-ний өдрөөс хойш овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл бүртгэгдээгүй, регистрийн дугаар өөрчилсний 1, нас барсны 3, нийт 4 бүртгэлтэй холбоотой өөрчлөлтийг тусгасан эсэхийг нягтлан шалгасан, 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдөр шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлсэн Т.Бадамханд /аж92101802/-ын мэдээллийг МТГ-т /86054080/ утсаар холбогдон, хэсгийн дугаарт харгалзуулан хаягаар хэсэг оноолгосон.

Монгол улсын харъяат болсон, харъяатаас гарсан, иргэний харъяаллыг сэргээн тогтоосны бүртгэл хийгдээгүй болно.

3. Аймгийн хэмжээнд иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр зогсоож, энэ өдрөөс өмнө шилжилт хөдөлгөөний бүртгэл хөтөлж, баталгаажуулаагүй бүртгэл байхгүй буюу бүртгэсэн, алдаатай төлөвтэй бүртгэл байхгүй.

2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр хөтлөгдсөн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг тухайн өдрийн 17 цаг 30 минутад баталгаажуулж дуусгасан. Шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргасан, дэвтэрт бүртгэсэн, иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүртгэж, баталгаажуулаагүй бүртгэл, ИУБ-22 маягт байхгүй.

Өгийнуур сумын Орхон 4-р багт 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс хойш шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгэгдсэн сум хооронд шилжин ирсэн 1, баг хооронд шилжин ирсэн 4, нийт 5 иргэдийн тоон мэдээг хавсралтаар хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/284 тоот тушаалаар нийслэл, 15 аймгийн, 2 дүүрэг, 43 сумын нийт 67 хэсгээс шилжин ирсэн бүртгэл хөтлөхгүй байхыг нийт улсын бүртгэгч нарт цаасан болон цахим хэлбэрээр анхааруулсан.

4. Сонгогчдын нэрийн жагсаалтад “Гадаадад 60 хоногоос дээш хугацаагаар зорчсон” тэмдэглэгээтэй 7 сонгогчийн мэдээлэл зөв болохыг сумын улсын бүртгэгчээр нягтлан шалгуулсан.

УДШ, ШШГЕГ, БХЯ, ЦЕГ, ГИХГ-уудаас нэмэлт тэмдэглэгээ хийсэн сонгогч байхгүй.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг өдөр бүр <http://192.168.154.143/> хаягаар шалган ажилласан ба сонгогчийн нэрийн жагсаалттай холбоотой гомдол, санал ирээгүй.

Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл /гар хурууны хээ/-д шинээр, 25, 45 насанд сольж, хаяж, гэж, үрэгдүүлсэн шалтгаанаар дахин олгох бүртгэлд бүртгүүлж байгаа иргэдийн бүртгэлийг баталгаажуулахдаа иргэний байнга оршин суух хаягийн мэдээлэл, сонгуулийн хэсэгт хамаарах нутаг дэвсгэрт бүртгэгдсэн эсэхийг тухай бүр нягтлан шалгасан.

5. Итгэмжлэгдсэн ажилтныг сонгохдоо төрийн албан хаагчаас сонгож, Тагнуулын хэлтсээс төрийн нууцтай харьцан ажиллах зөвшөөрлийг авсан. 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдөр итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулж, нууцын баталгаа гаргуулан, тусөдөр УБЕГ-аас онлайнаар зохион байгуулсан сонгуулийн эрх зүйн сургалтад хөтөлбөрийн дагуу оролцуулсан.

6. Сонгуулийн хэсэгт оноогдоогүй сонгогчийг тухай бүр хэсэгт оноосон, сонгогчдын нэрийн жагсаалтыг <http://192.168.154.143/> хаягаар өдөр бүр нягтлан шалгаж байсан, ямар нэг зөрчил гараагүй болно.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх эрх хүссэн албан бичгийг 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр УБЕГ-ын ИУБГ-т хүргүүлж, иргэний улсын ахлах бүртгэгчид эрх авсан.

2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр гэхэд сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэхэд шаардлагатай бичгийн цаас, принтерийн хор гэх мэт бусад, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгаж бэлтгэсэн.

Иргэний улсын ахлах бүртгэгч Ц.Мөнхтамирт олгосон эрхийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 09 цаг 15 минутад 1 хэсгийн 428 сонгогчдын нэрийн

жагсаалтыг 2 хувь хэвлэн, 09 цаг 20 минутад сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх эрхийг хаах тухай ИУБГ-т цахимаар мэдээлсэн.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх явцад программ болон сүлжээ хэвийн ажилласан ба хэсэг тус бүрийн эхний дугаарын сонгогч, сүүлийн дугаарын сонгогч тус бүрээр нягтлан шалгаж, жагсаалт үйлдэн, Хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, иргэний улсын ахлах бүртгэгч нар хяналт тавьж, алдаа зөрчил гараагүй болно.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг 2 хувь хэвлэн, хэлтсийн дарга, иргэний улсын ахлах бүртгэгчийн тамга, гарын үсгээр тус тус баталгаажуулан, цаасан хэлбэрээр, хүлээлцэх актын хамт дугтуйлсан.

2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр сумын сонгуулийн хороог бүрэлдэхүүнээр нь цуглуулж, сонгогчдын нэрийн жагсаалтын 1 хувийг хэсгийн хороонд, 1 хувийг итгэмжлэгдсэн ажилтанд тус тус хүлээлгэн өгч, сонгогчдын нэрийн жагсаалт хүлээлцэх актыг хэсгийн хорооны ахлахын тамгаар баталгаажуулан, тэмдэглэлийн хамт хэлтэст буцаан авч ирсэн болно.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн ажилтай холбоотой илтгэх хуудсуудыг n.narantsetseg@burtgel.gov.mn хаягаар хүргүүлэн ажилласан.

Хэлтсийн 70332143 утсанд сонгогчийн нэрийн жагсаалттай холбоотой гомдол, санал ирээгүй.

2.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр :

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Тэмдэгтийн хураамжын тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Архивын тухай хууль, эдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журмуудыг өдөр дутмын үйл ажиллагаандаа баримтлан 2022 оны эхний хагас жилийн байдлаар иргэн , хуулийн этгээдээс нийт **2767** мэдүүлэг хүлээн авч доорхи бүртгэлийг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Газраас бусад ҮХЭХ-ийг анхны удаа бүртгэж баталгаажуулах -157
2. Шинээр баригдсан орон сууц анх удаа бүртгэж баталгаажуулах -38
3. Төрөөс үнэгүй хувьчилсан газрын өмчлөх эрхийг баталгаажуулах-192
4. Бэлэглэх гэрээ -130
5. Худалдах худалдан авах гэрээ-445
6. Өмчлөгчийн хүсэлтээр бүртгэлд өөрчлөлт оруулах-114

7. Гэрээслэл болон өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх-50
8. Барьцаалбаргүй барьцааны гэрээ-443
9. Барьцаалбартай барьцааны гэрээ-259
10. Барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах-79
11. Барьцааны гэрээ дуусгавар болгох-735
12. Үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр олгох-32
13. Лавлагаа-35
14. Хувийн хэрэг бүртгэлийг хаах-10
15. Хуулбар-26

Эдгээр бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлсний үр дүнд жилийн эцсийн байдлаар улсын төсөвт үйлчилгээний хураамжаар **23,626,663** төгрөг, орон нутгийн төсөвт тэмдэгтийн хураамжаар **1,111,616** төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны албан татвар **92,021,960** төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна. Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг эхлүүлэх хүрээнд Эхний хагас жилийн байдлаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг сумын төвөөс үзүүлэх эрх авсан Хангай, Жаргалант, Өгийнуур сумдын улсын бүртгэгч нар нийт 66 мэдүүлгийг хүлээн авч бүртгэлийг хийж иргэдэд түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Монгол Улсын хаягжуулалтын тухай хууль тогтоомжий дагуу Сумын засаг даргын тамгын газар, газрын даамал сумдын улсын бүртгэгч нартай хамтран Булган, Батцэнгэл, Ихтамир, Хайрхан, Эрдэнэмандал суманд шинээр хаягжсан гудамж үл хөдлөх хөрөнгийн хаягийг шинэчлэх, гэрчилгээг солих арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

Хаягжуулалтын журам, газрын мэдээллийн сангийн шинэчлэлтэй холбоотойгоор нийт **183** эд хөрөнгийн хаяг өөрчилсөн бүртгэлийг хийгээд байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/427 дугаар тушаалаар батлагдсан барьцааны гэрээ, гэрээний өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт ЭУБ-06, ЭУБ-13 маягтаар бүртгэлийг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн бүртгэж эхлээд байна.

Холбогдох хууль тогтоомж дүрэм журамд заасан хуулиар хориглоогүй аливаа мэдээ мэдээллийг иргэдэд байгууллагын пэйж хуудсаар дамжуулан ил тод нээлттэй өгч ажиллаж байна.

3.Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр

2022 оны эхний хагас жилийн байдлаар шинээр үүсгэн байгуулагдсан нийт 90 аж ахуй нэгж

Үүнд:

хязгаарлагдмал хариуцлагатай компани 46

нөхөрлөл 9

хоршоо 15

төрийн байгууллага албан газар 3,

төрийн бус байгууллага 20

үйлдвэрчний эвлэл 3

салбар төлөөлөгчийн газар 5

-ийг тус тус бүртгэж улсын бүртгэлийн гэрчилгээ олголоо. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт **210**, шинэ оноосон нэрийн хүсэлт **136**, татан буугдсан **5**, дахин гэрчилгээ **31**, хэлбэр өөрчилсөн **28**, шилжилт хөдөлгөөн хийсэн **5-н** бүртгэлийн үйлчилгээг хууль, журманд нийцүүлэн, түргэн шуурхай үзүүлсэн.

Тайлангийн хугацаанд 279 хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээнд нь холбогдох бичилтийг хийж баталгаажуулж, архивт шилжүүлсэн болно.

Улсын бүртгэлийн гэрчилгээгээ үрэгдүүлсэн, солих хүсэлт гаргасан **31** хуулийн этгээдийн баримт бичгийг хүлээн авч хянан үзээд дахин улсын бүртгэлийн гэрчилгээ олголоо. Иргэн, хуулийн этгээд тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх, ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих журмын хэрэгжилтийн хүрээнд 123 хуулийн этгээдэд тамга, тэмдэг хийлгэх хяналтын хуудас олгож, **33** хуулийн этгээд тамга, тэмдгээ хураалгасан байна. Тухайн жилд нийт **442** бүртгэлийг цахим санд бүртгэж баталгаажуулсан байна. Хагас жилийн байдлаар **90** шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хуулийн хүрээнд тогтоож, цахим санд шинээр бүртгэгдсэн. Нэмэлт өөрчлөлт хийлгэсэн хуулийн этгээд **210**, нийт **87** хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгэх ажлыг зохион байгуулав. 2022 оны эхний хагас жилийн байдлаар төрийн байгууллагад **18**, иргэн хуулийн этгээдэд **5** лавлагаа хууль журмын дагуу олгож, холбогдох бүрдүүлбэрийг архивт хүлээлгэн өгсөн байна.

Хуулийн этгээдийн нэрийн баталгаажилтыг **136** хуулийн этгээдэд хийсэн байна.

4. Хяналтын улсын байцаагчийн чиглэлээр

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/341 дугаар тушаалаар батлагдсан Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх

журам болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд иргэний улсын бүртгэлийн 574, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 52, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 130, архивын 96 бүртгэлд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт тавьж сар бүр тоон мэдээг Хяналт, шалгалтын газарт хүргүүлэн ажиллаж байна. Илэрсэн 144 зөрчлөөс 135 зөрчлийг тухай бүр нь арилгуулан ажиллаа. Улсын бүртгэгч нарыг мэргэжил арга зүйн удирдалагаар ханган ажиллаж байна.

Иргэн, хуулийн этгээдээс гаргасан иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой 100 өргөдөл, гомдлыг хүлээн авч, түүний дагуу 95 улсын байцаагчийн дүгнэлт үйлдэн Хяналт, шалгалтын газраар хянуулан ажилласан байна. Эдгээр дүгнэлтүүдийг ангилвал:

Иргэний улсын бүртгэлийн -70

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн - 2

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 23 дүгнэлт гаргасан байна. Улсын бүртгэлийн мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 158 бүртгэлд 60 дүгнэлтээр засвар өөрчлөлт оруулсан. Гаргасан дүгнэлтийнхээ шийдвэрлэлтийн байдалд байнгын хяналт тавьж, шийдвэрлэгдсэн тухай бүр өргөдөл гаргагч иргэнд утсаар тухай бүр хариу өгч түргэн шуурхай байдлыг ханган ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн хугацаатай үүрэг даалгаварын биелэлтийг тухай бүр нь хийж гүйцэтгэн, албан бичгээр хариуг хүрүүлэн ажиллаж байна. Үүнд:

Хяналт шалгалтын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 7/3496 дугаар албан бичгээр ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу Өгийнуур сумын Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийг дуустлах хугацаанд бүртгэгдсэн нийт 9 бүртгэлийг шалгаж, илтгэх хуудасыг хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажиллаа.

Батцэнгэл, Эрдэнэмандал, Хайрхан, Ихтамир, Эрдэнэбулган сумдад зохион байгуулагдсан “Нээлттэй хаалгаын” өдөрлөгт иргэдэд Улсын бүртгэлийн хууль, тогтоомж, Зөрчлийн тухай хуулийн талаар зөвөлгөө мэдээлэл хүргэн ажиллаа.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны талаар аймгийн Прокурорын байгууллагатай байнга хамтран ажиллан, өдөр тутам заавар зөвлөмж авч, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль тогтоомжид заасан хугацаанд явуулж байна.

Тогтоосон хугацаанд иргэний улсын бүртгэлд бүртгүүлээгүй, тогтоосон журам зөрчсөн зөрчилд хяналтын улсын байцаагчийн эрх хэмжээний хүрээнд 224 зөрчилд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу мөнгөн торгууль ногдуулж **4.760.000** төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээд байна.

5. Улсын бүртгэлийн архивын чиглэлээр:

Архивын сан бүрдүүлэлтийн талаар

Тус хугацаанд иргэний бүртгэлийн тасгийн архивын фондоос **4302** иргэний хувийн хэргийг шүүж, **28** иргэний зөрчилтэй маягтыг нөхөн бүрдүүлэлтээр шивж, баталгаажуулан зөрчлийг арилгаж, сарын мэдээгээр ирсэн 7 терлийн бүртгэлийн **1150** ширхэг, шилжилт хөдөлгөөний **461** ширхэг, харяалал харгалзахгүй бүртгэл хийлгэсэн иргэдийн **508**, албан тоотоор ирүүлсэн **403** иргэний хувийн хэргийн ХААТР, ИУБ маягтуудыг эмхэлж цэгцлэн, цагаан толгойн үсгийн дарааллаар галиглах ажлуудаг шат дараалан хийж, иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн **1938** иргэний ИУБ-31 маягтыг журмын дагуу галиглан “А” талыг УБЕГ-т хүргүүлэн, “Б” талыг архивт байршуулав.

Нэгдсэн архивын даргын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 10/787 тоот чиглэлийн дагуу иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд эцэг, эхийн мэдээлэл бүртгэгдээгүй, зөрүүтэй **243** иргэний нэрсийн жагсаалтыг хүлээн авч:

а. 230 иргэний ИУБ/ХААТР/ маягтын Б талыг архиваас татан авч, санд шивэн баталгаажуулсан.

б. Өөр аймаг, нийслэлд шилжин суурьшсан 11 иргэний ИУБ/ХААТР/ маягтын Б талыг харъяалагдах аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс рүү утсаар холбогдож цахимжуулсан.

в. 2 иргэний ИУБ/ХААТР/ маягтын Б тал архивт байхгүй тул төрөлтийн бүртгэлийн дэвтэрийг үндэслэн нөхөн бүртгэлээр санд шивэн баталгаажуулсан.

Хяналт шалгалтын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 7/811 тоот үүрэг, чиглэлийн дагуу 2021 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд бүртгэгдсэн 4690 бүртгэлийн ИУБ маягт, нотлох баримтуудыг сканердаж, PDF хэлбэрээр хавтас үүсгэн хадгалахаас 2021 оны **4384** бүртгэлийн ИУБ маягтуудын Б талыг архиваас татан авч, Нэгдсэн архивын газрын С.Оюунгэрэл даргатай утсаар холбогдон зөвшөөрөл авсаны үндсэн дээр, **19368** нотлох баримт, ИУБ маягтуудыг сканердаж 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд цахимжуулж дуусгасан.

Цахимжуулсан баримтын тоог сум тус бүрээр гаргавал:

№	Сумыннэр	ИУБ-11		ИУБ-12		ИУБ-13		ИУБ-14		ИУБ-15		ИУБ-16		ИУБ-18		ИУБ-22	
		2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022
1	Батцэнгэл	45	4	1	1	2	0	4	0	9	0	2	0	13	1	9	5
2	Ихтамир	91	9	2	0	5	0	6	0	22	6	0	2	35	2	44	12
3	Тариат	80	4	1	1	2	0	4	0	15	1	1	0	24	4	60	2
4	Төвшрүүлэх	42	0	0	0	1	0	2	0	23	1	0	0	15	1	25	4
5	Чулуут	56	0	1	0	1	0	1	0	43	1	1	0	14	1	17	1
6	Хашаат	54	0	2	0	0	0	0	0	6	0	1	0	16	1	49	4
7	Хангай	62	6	1	0	1	0	1	0	25	1	0	1	18	4	36	4
8	Хайрхан	59	7	2	0	2	0	2	1	24	0	0	0	23	0	27	4
9	Булган	43	4	2	0	1	0	2	0	7	0	0	0	12	0	50	7
10	Жаргалант	70	0	2	0	5	0	3	0	14	0	1	0	32	1	24	0
11	Өгийнuur	49	7	4	0	5	0	1	0	20	0	0	0	16	1	34	1
12	Өлзийт	67	2	1	0	6	0	0	0	18	3	3	0	22	4	25	5
13	Өндөрүлаан	106	10	6	0	5	0	3	0	40	1	1	0	29	1	44	0
14	Хотонт	65	5	0	0	1	0	0	0	15	1	1	0	34	1	55	3
15	Цэцэрлэг	48	7	0	3	3	0	4	0	12	2	0	0	20	2	25	1
16	Эрдэнэбулган	482	13	11	1	13	5	19	0	131	5	19	0	108	12	566	41
17	Цэнхэр	82	7	1	0	3	0	3	0	23	2	1	0	24	2	72	5
18	Цахир	42	1	0	0	4	0	1	0	15	1	4	0	13	5	21	7
19	Эрдэнэмандал	122	1	1	0	6	0	10	0	54	0	2	0	33	1	46	0
20	Хэлтэс	161	16	1	0	0	0	0	0	30	3	10	1	64	9	0	0
Нийт		1826	103	39	6	66	5	66	1	546	28	47	4	565	53	1229	106
Цахимжуулсан баримтын тоо		7504		117		198		198		3276		235		1695		6145	

Нэгдсэн архивын даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 10/1536 тоот чиглэлийг улсын бүртгэгч нарт танилцуулан, иргэний баримтын цахимжуулалт болон тайлан, мэдээний тал дээр анхаарч ажиллахыг үүрэг болгон ажиллаж байна.

2006 онд төрсөн 1846 хүүхдийн ХААТР, ИУБ маягыг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нягтлан шалгаж:

а. Өөр аймаг, нийслэлд шилжин суурьшсан 262 иргэний ХААТР, ИУБ маягыг харьяа аймаг, нийслэл рүү албан тоотоор хүргүүлсэн.

б. Нас барсан 9, зөрчилгүй 1319, нийт 1328 иргэний ХААТР, ИУБ маягыг архивт байршуулсан.

в. Ургын овгийн зөрүүтэй, эцэг, эхийн мэдээлэл шивэгдээгүй, зөрүүтэй 181 иргэний алдааг засвар өөрчлөлтийн бүртгэлээр залруулсан.

г. Эх нотлох баримтаас зөрүүтэй 8 иргэний алдааг ХУБ-ийн дүгнэлтээр залруулхаар, 67 иргэний алдааг нэгдсэн дүгнэлтийг үндэслэн залруулхаар ИБЗ-1 маягтын хамт УБЕГ-т хүргүүлсэн.

2022 оны 03 дугаар сард “ДОНДОГБОРЖИГОН” ХХК-аар шинэ төрлийн COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байранд ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг 1 удаа зохион байгуулсан.

2022 оны 03 дугаар сарын 24-нд ИУБ-21 маягт 3147 ширхэг, иргэний улсын бүртгэлийн баримтыг архивт хүлээлгэн өгсөн тухай дагалдах хуудас 1 боть 250 хуудас, иргэний үнэмлэх дахин олголтын анкет, бүртгэлийн дэвтэр 30 боть 2759 хуудас, шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэр, бүрдүүлбэрийн хамт 19 боть 4810 хуудас, лавлагаа олгосон бүртгэлийн дэвтэр 10 боть 2326 хуудас, түр олгох баримтын бүртгэлийн дэвтэр 7 боть 1475 хуудас, нийт 67 ширхэг хадгаламжийн нэгж 14767 хуудас баримт бичгийг тус тус устгасан.

Тодорхойгүй 11012 ширхэг маягтаас 2 хадгаламжийн нэгжийн 1686 ширхэг ХААТР, ИУБ маягтуудыг нягтлан шалгаж, дараах байдлаар ангилан ялгалаа. Үүнд:

д/д	Ангилалт	А үсэг	Б үсэг	Нийт
1	Нас барсан	95	382	477
2	Архивт үлдсэн	428	341	769
3	Харъяатаас гарсан	3	2	5
4	Архивт байршуулах	112	140	252
5	Өөр аймагт хаягтай /албан тоотоор хүргүүлсэн/	21	33	54
6	Нийслэлд хаягтай /албан тоотоор хүргүүлсэн/	62	67	129
		721	965	1686

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд цаасан хувийн хэргийг тулган шалгаж зөрүүтэй мэдээллийг засварлах ажлыг зохион байгуулан **580** ширхэг хувийн хэргийг цахим санд тулган шалгаж мэдээлэл зөрүүтэй 35 бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн 1500 дүгнэлтээр зассан. Тусгаарлагдсан нийт **3965** хуудсыг хувийн хэргээс авч 250 хадгаламжийн нэгж үүсгэсэн. Тусгаарласан хуудсыг ЭХЭУБГазрын даргын 2022 оны 6/3763 тоот чиглэлийн дагуу усгалд оруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

Хэлтсийн бусад үйл ажиллагаа

1. Санхүү бүртгэлийн талаар

Тус хэлтэс нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар 217,531,700 төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт батлагдсанаас 216,775,731.37 төгрөгийн санхүүжилтийг зохих журмын дагуу зарцуулж 755,968.63 төгрөгийн төсвийн хэмнэлттэй өр авлаггүй ажиллаж байна. 2021 оны санхүүгийн баримтанд Үндэсний

аудитын газрын харъяа аймгийн аудитын газраас үе шаттай хяналт шалгалт хийж жилийн эцсийн санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлтийн гэрчилгээ олгосон. Төсөв санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны бүртгэлийн батлагдсан заавар аргачлалын дагуу бүртгэж баримтын бүрдлийг ханган ажилласан.

Төсвийн тухай хууль НББ-н тухай хуулийг үндэслэн батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, зарцуулан байгууллагынхаа үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэн өр авлагагүй ажилласан.

Санхүүгийн тайлан болон сарын мэдээ, үнэт цаасны тайлан, татвар, нийгмийн даатгалын тайланг цаг хугацаанд нь үнэн зөв гарган холбогдох байгууллагад хүргэн ажилласан. Шилэн дансанд байршуулах ёстой 65 мэдээллийг батлагдсан хуваарийн дагуу цаг тухайд нь байршуулан ажиллаж байгаа бөгөөд байгууллага шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээллэж байгаа бөгөөд байгууллагын цахим хууданд шилэн дансны бие даасан цэстэй, мэдээлэл татаж авах боломжтой бөгөөд мэдээллийг цаг тухайд нь шинэчлэн ажиллаж байна. Үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах үнэт цаас болон түүний дагалдах материалыг үнэт цаас авах тухай хүсэлт болон албан тоотыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт гарган үнэт цаас авахдаа нэр төрөл тус бүрээр нь тулган шалгаж Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирсэн зарлагын баримтын дагуу бүртгэж, бүртгэгч байцаагч нараас сар бүрийн 25 ны дотор үнэт цаас, үйлчилгээний орлогын тайланг авч Улсын бүртгэлийн ерөнхий газарт нэгтгэн хүргүүлж байна. Улсын бүртгэгч байцаагч нарын үнэт цаасны тайлан, тооцоо бодсон актыг үндэслэн хүчингүй болсон буюу дутагдсан үнэт цаасны тайланг авч албан хаагчдын буруутай үйлдлээс болж гэмтсэн, үрэгдсэн гэрчилгээг УБЕГ-ын даргын 2021 оны а/707 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан гэрчилгээ маягт түгээх, зарцуулалтанд хяналт тавих, тайлагнах журам-д заасан үнээр төлүүлж үндсэн үйл ажиллагааны орлого төвлөрүүлдэг дансанд төлүүлэн ажиллаж эхэлснээр үнэт цаас хүчингүй болох нь багассан. Хэлтсийн даргын тушаалаар томилогдсон тооллогын комисс үндсэн хөрөнгийн тооллогыг явуулж, тооцоог бодож дуусган илтгэх хуудсаар тооллогын дүнг Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн үр дүнг тайлагнасан.

2. Мэдээлэл технологийн чиглэлээр :

Хэлтсийн болон сумдын улсын бүртгэгч нарын тоног төхөөрөмжийг 2021 оны 10 дугаар сард Койекагийн санхүүжилтээр бүрэн шинэчилж иргэнд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан. Сумдын улсын бүртгэгч нарын тоног

төхөөрөмж бүгд хэвийн ажиллаж байна. Албан хаагч нарт ашиглагдаж буй тоног төхөөрөмжүүдийн аюулгүй байдлын хангаж хэвийн ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн сүлжээний хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангаж ажиллаж байна. Техникийн гэмтэл болон вирустэж ажиллагааны горим алдагдсан компьютер хэрэслийг цаг алдаггүй засаж сэлбэж, тэжээлийн блок их хавтан гэх мэт жижиг механик, программын гэмтэл гарсан тохиолдолд тухай бүр үзэж шалган арга хэмжээг авч ажиллаа.

Үйлчилгээний танхимд “Цахим хөтөч” булан нээж гар утсаараа үйлчилгээ авах боломжгүй иргэдэд зөөврийн компьютер байрлуулан улсын бүртгэгч нар хуваарийн дагуу E Mongolia цахим системийг иргэдэд зааж өгч зөвлөн туслах хэлбэрээр үйлчилгээ үзүүлж байна.

3.Тоног төхөөрөмж засвар үйлчилгээний талаар

Сумдын улсын бүртгэгч нарын тоног төхөөрөмж бүгд хэвийн ажиллаж байна. Албан хаагч нарт ашиглагдаж буй тоног төхөөрөмжүүдийн аюулгүй байдлын хангаж хэвийн ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн сүлжээний хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангаж ажиллаж байна. Техникийн гэмтэл болон вирустэж ажиллагааны горим алдагдсан компьютер хэрэслийг цаг алдаггүй засаж сэлбэж, тэжээлийн блок их хавтан гэх мэт жижиг механик, программын гэмтэл гарсан тохиолдолд тухай бүр үзэж шалган арга хэмжээг авч ажиллаа.

1. Хэлтсийн хэмжээнд ажиллаж байгаа тоног төхөөрөмжийг тухай бүрд засвар үйлчилгээг хийж байна.
2. Серверийн өрөөнд чийгтэй цэвэрлэгээг 14 хоногт 1 удаа хийж серверийн өрөөний бүртгэлийн дэвтрийг хөтлөн ажиллаж байгаа.

4.Албан бичиг хөтлөлтийн талаар

2022 оны эхний хагас жилийн байдлаар тус хэлтэст нийт ирсэн албан бичиг 613 , явсан албан бичиг 865, өргөдөл, гомдол 118 ирсэн байна. Хугацаатай буюу хариутай албан бичгээс 613 албан бичгийг цаг тухайд нь албан байгууллага, иргэдэд хүргүүлэн ажиллаа.


Нийт ирсэн албан бичгийг ангилж үзвэл:

- ❖ УБЕГ – 40
- ❖ Шүүх – 190
- ❖ Аймгийн засаг дарга, ЗДТГ-аас – 30
- ❖ Цагдаа, Прокурорын байгууллагаас – 190
- ❖ ШШГЕГ, аймгийн ШШГГ – 20


- ❖ Бусад аймгийн УБХ, НУБГ-аас - 20
- ❖ Сумдаас - 15
- ❖ Бусад байгууллагаас – 20 ирж хариуцсан албан хаагчдад өгч шийдвэрлүүлж ажиллаа.

5.Сургалт, семинар зохион байгуулсан байдал:

Хэлтсийн албан хаагчдыг цаг үеийн мэдээ мэдээллээр хангах үүднээс сумдын улсын бүртгэгч болон хэлтсийн албан хаагч нарт 2022.01.10-ны өдөр хэлтсийн дарга “ХАСХОМ, авлига ашиг сонирхлоос ангид байх”, “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах”, мэдээ мэдээлэл өглөө.



2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Хуульчийн про боно өдөр”, 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн тусгайлсан чиг үүргийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөр”-үүдээр хэлтсийн албан хаагчид “Тоон гарын үсэг”-ийн талаар иргэдэд сурталчлан, 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 6 дунд сургууль, МУБИС-ийн салбар сургууль, Нэгдсэн эмнэлэг, Эрчим, Онцгой байдлын газар зэрэг байгууллагуудад тоног төхөөрөмж байрлуулан үйлчилж нийт **1808** иргэнд тоон гарын үсэг олгон ажилласан байна.



Хэлтсийн үйлчилгээний танхим болон 2 давхарын мэдээллийн самбаруудад бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой гарын авлага, боршур, мэдээлэлтэй танилцах боломжтой байдлаар байрлуулсан.

[Www.arkhangai.burtgel.gov.mn](http://www.arkhangai.burtgel.gov.mn) сайтаар бүртгэлийн үйлчилгээ, болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.

2022 оны 04 дүгээр сарын 14,15-ны өдрүүдийн сургалт, 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн үндэсний энгийн гадаад паспорт, иргэний үнэмлэхийн хүчингүй болгох бүртгэлийн тухай цахим чиглэлийн дагуу 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Цэцэрлэг сумын иргэн О.Бямбажаргал /ан02320711/, Өгийнуур сумын иргэн Л.Бөөрөлжин /ны76010264/ нарын иргэний үнэмлэхийн хүчингүй болгох бүртгэлийг бүртгэсэн.

2022.04.30-ны өдөр Тагнуулын хэлтсийн мэргэжилтэн Билгүүнээс “Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалт” сэдвээр 19 сумын улсын бүртгэгчид болон хэлтсийн албан хаагч нарт онлайнаар сургалт авлаа. Мөн “Цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах түүний аюулгүй байдлыг хангах журам”-ын 5 дугаар зүйл “Мэдээллийн аюулгүй байдал”-ын программын дагуу нууц үгийг тогтмол сольж хэвших талаар Хяналтын улсын байцаагчтай хамтран сумдын болон хэлтсийн албан хаагчдад мэдээлэл өгсөн.

2022.04.07-нд “Хоршооны шинэчилсэн бүртгэл”-ны сургалтанд хуулийн этгээдийн улсын бүртгэгч С.Баттулга, 2022 оны 03 дугаар сарын 28-ны “Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг архивт хадгалах журам”, “Албан хэрэг хөтлөлтийн тухай” хэлтсээс зохион байгуулсан цахим сургалтад, 2022 оны 01 дүгээр сарын 27-ны “Иргэний улсын бүртгэлийг цахимаар хөтлөх”, 2022 оны 02 дугаар сарын 18-ны “2022 оны 522 тоот чиглэлийн талаар мэдээлэл хүргэх”, 2022 оны 03 дугаар сарын 11-ний “Архивын цахимжуулсан программд мета дата оруулах”, “Авлигын эсрэг давтан сургалт”, 2022 оны 03 дугаар сарын 31-ний “Харилцаа ба гэмт хэрэг”, 2022 оны 04 дүгээр сарын 01-04, “Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх, танилцуулах”, 2022 оны 04 дүгээр сарын 02-ны ЭХЭУБГазраас улсын бүртгэгч нарт зориулсан онлайн сургалт, 2022 оны 05 дугаар сарын 20-ны “Жендерийн тэгш байдлыг хангах тухай” 2022 оны 05 дугаар сарын 24-ний “Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх”, “Сонгуулийн журмын талаар”, 2022 оны 05 дугаар сарын 30-ний “Хуурамч бичиг баримт, түүнээс урьдчилан сэргийлэх”, 2022 оны 06 дугаар сарын 08-ны “E-Mongolia системээр иргэний үнэмлэх, гадаад паспорт, шилжилт хөдөлгөөний бүртгэл хөтлөх” тухай УБЕГ-аас зохион байгуулсан онлайн сургалтад

тус тус хамрагдсан болно. 2022 оны 04 дүгээр сарын 14,15-ны өдрүүдэд УБЕГ-аас зохион байгуулагдсан “Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх, танилцуулах”, “Тоон гарын үсэг олгох тухай” хуулийн сургалтад Хэлтсийн дарга, Мэдээлэл технологийн ажилтан, Иргэний улсын ахлах бүртгэгч нар оролцож удирдлага, арга зүйн зөвлөгөө авсан болно. 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр иргэний улсын бүртгэл хөтлөх, “Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх, танилцуулах” тухай сумдын улсын бүртгэгч нарт зориулсан цахим сургалтыг зохион байгуулсан. 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр “Улсын бүртгэлийн байгууллагаас Монгол улсын 16 насанд хүрсэн иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам”-ын тухай “Хүүхдийн номын сан”-д танхимын сургалтыг зохион байгуулж, УБЕГ-ын Хяналтын улсын ахлах байцаагч Ч.Эрдэнэчимэг, хяналтын байцаагч н.Баатар, А.Мөнхцэцэг, Т.Золбаяр нараас хэлтсийн бүх албан хаагчид удирдлага, арга зүйн зөвлөгөө авсан.

Мөн АТГ-аас зохион байгуулсан 6 удаагийн давтан сургалт, ТАЗ-өөс зохион байгуулсан 7 удаагийн давтан сургалтад тус тус цахимаар оролцсон.

6.Мэдээллийн ил тод байдлын талаар

2022 онд “Архангайн амьдрал” сонин, АВ, Тамир телевизтэй хамтран ажиллах уг орон нутгийн сонин, телевизээр дамжуулан мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх зорилт тавин ажиллаж байна. “АВ” болон “Архангай” телевизүүдэд, “Архангайн амьдрал”, “Архангайн толь” сонингуудад байгууллагын үйл ажиллагааг цаг тухайд нь иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад сурталчлан таниулах ажлыг шат дараалалтай хийгдэж байна.

“Зөрчлийн тухай хууль”-ийг сурталчлан таниулах ажлын хүрээнд 16, 25, 45 нас хүрч байгаа иргэдийг цахим үнэмлэхээ хугацаандаа авах, сунгуулах тухай үгэн зар, мэдээг “АВ” болон “Архангай” телевизүүдээр байнга сурталчлан ажиллаж байна.

2021 оны 04 дүгээр сараас эхлэн “Мобиком Корпораци” ХХК-ний хэрэглэгчдэд масс мессеж үйлчилгээгээр 16, 25, 45 насанд хүрсэн цахим үнэмлэхээ аваагүй, сунгуулаагүй иргэдэд” **Иргэн та 16, 25, 45 насанд хүрсэн бол 1 сарын дотор цахим үнэмлэхээ захиална уу. Хугацаа хэтэрвэл торгуультай**” гэсэн мессежийг хүргүүлэн, www.burtgel.gov.mn, www.burtgel.ar.gov.mn сайтуудаар бүртгэлийн үйлчилгээ, болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.



Irgen ta 16, 25, 45 nasand
hursen bol 1 sariin dotor
tsahim unemiehee zahialna
uu! Hugatsaa hetervel
torguulitai. Arhangai aimgiin
ULSIIN BURTGELIIN HELTES

17:29

- ✓ Иргэдэд E Mongolia цахим хуудсыг ашиглан бүртгэлийн үйлчилгээ авах талаар мэдээлэл видео бичлэгийг байнга хүргэж байна.
- ✓ Улсын бүртгэлийн хэлтсийн <https://arkhangai.burtgel.gov.mn/> веб хуудас **Архангай улсын бүртгэлийн хэлтэс** facebook хуудсыг давхар ажиллуулж мэдээ мэдээллийг байршуулж мөн **Архангай аймгийн ЗДТГазар** орон нутгийн **АВ**, ТВ-тэй хамтран сар болгон мэдээлэл өгч ажиллаж байна.
- ✓ Тус хэлтэс нь 19 сумын улсын бүртгэгч нартай сар болгон ONLINE хурал хийж мэдээ мэдээллийг цаг тухай бүрд хүргэж ажиллаж байна.

7. Иргэд байгууллагад олгосон лавлагааны талаар:

Тус хэлтсийн хэмжээнд эхний хагас жилийн байдлаар төрийн байгууллага иргэн, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 4586 лавлагааг хууль журмын хүрээнд гарган хүргүүлсэн байна. Үүнд:

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэд, байгууллагад 4309 лавлагааг гарган үйлчилсэнээс:

Албан хэрэгцээнд үнэ төлбөргүй – 263 лавлагаа

Төрсний – 349 лавлагаа

Төрөлт бүртгэлгүй - 1 лавлагаа

Төрөл садангийн - 89 лавлагаа

Үрчлэлтийн - 26 лавлагаа

Ургын овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэлийн - 14 лавлагаа

Эцэг /эх/ тогтоосон тухай - 8 лавлагаа

Гэрлэсэн тухай – 86 лавлагаа

Гэрлэлт бүртгэлгүй тухай - 29 лавлагаа

Гэрлэлт дуусгавар болсон тухай - 8 лавлагаа

Нас барсны - 228 лавлагаа

Регистрийн дугаар өөрчилсөн - 12 лавлагаа

Регистрийн дугаарын – 1 лавлагаа

Байнга оршин суугаа хаягийн - 86 лавлагаа

Иргэний үнэмлэхийн хуулбар - 686 лавлагааг бүртгэлийн хуулбар болон бусад бичиг баримтыг үндэслэн шүүх, цагдаа, прокурор зэрэг төрийн болон төрийн бусад байгууллагад албан тоотоор 715 иргэний үнэмлэхийн хуулбарыг, сумдын бүртгэгч нар 1708 лавлагааг иргэдэд тус тус олгосон байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд-61, төрийн байгууллагад -193 лавлагааг цаасан хэлбэрээр гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаа.

Хуулийн этгээдийн мэдээллийн сангаас иргэнд-5, төрийн байгууллагад -18 лавлагааг цаасан хэлбэрээр гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаа.

“НЭЭЛТТЭЙ ХААЛГА”-НЫ ӨДӨРЛӨГ:

Эхний хагас жилийн байдлаар нийт 5 сумын засаг даргын тамгын газар, газрын даамал сумдын улсын бүртгэгч нартай хамтран Булган, Батцэнгэл, Ихтамир, Хайрхан, Эрдэнэмандал суманд Нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж нийт 254 Эд хөрөнгө, Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн мэдээлэл зөвлөгөөг өгч бүртгэлийг газар дээр нь хийж гэрчилгээг олгон ажиллаа.



2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Хуульчийн про боно өдөр”, 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн тусгайлсан чиг үүргийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөгт оролцон Улсын бүртгэлийн үйлчилгээг олон нийтэд сурталчилан ажиллаа.

“ХУУЛЬЧИЙН ПРО БОНО ӨДӨР-2022”
2022.05.02
Хуулийн байгууллагууд хамтран хууль, эрх зүй зүйн зөвлөгөө, мэдээлэл үнэ төлбөргүй өгөх өдөрлөгийг Г.ДЭМИД ЖАНЖИНЫ ТАЛБАЙД зохион байгуулна.
Монголын Хуульчдын Холбооны тусламж үйлчилгээний өвөр
75050801, 75050802, 75050803, 75050804
дугаарын утсаар иргэнд хууль, эрх зүйн зөвлөгөөг үнэ төлбөргүй өгнө.



Хэлтсийн албан хаагчид “Тоон гарын үсэг”-ийн талаар иргэдэд сурталчлан, үйлчилж нийт 109 иргэнд тоон гарын үсэг олгож, 5 иргэний үндэсний энгийн гадаад паспортыг олгон ажилласан байна.

ШИНЭЛЭГ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Хэлтсийн алба хаагч бүр сар бүр шинэлэг ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд хэлтсийн үйлчилгээний заалыг тохижуулах, үйлчлүүлэгчийн ая тухтай орчинг бий болгох, албан хаагчдын

харилцаа хандлага ёс зүйн талаар дотоодын сургалтуудыг зохион байгуулсан ажиллаж байна.

2022.03.08-ны өдөр “Ээждээ захидал бичээрэй” уралдааныг албан хаагчдын хүүхдүүдийн дунд зохион байгуулж Өгийнуур сумын улсын бүртгэгч Д.Оюунбаатарын охин П. Анударь түрүүлэн дурсгалын зүйлээр шагнагдсан.




2022.03.08, 18-ны өдрүүдэд төрсөн 3 охин, 1 хүүд Иргэний улсын бүртгэлийн архивч нярайн дээл урлан оёж, дурсгалын зүйлийг төрсний гэрчилгээний хамт гардуулан өгсөн.



Мөн үйлчилгээний танхимд “Гэрлэх ёслолын булан”-г тохижуулж аймгийн төвийн сум болох Эрдэнэбулган суманд гэрлэлтээ батлуулсан хосуудад гэрлэлтийн гэрчилгээг хүндэтгэлтэйгээр гардуулж эхлээд байна.

Байгууллын бүх мэдээллийн самбарын шинэчлэн, хаягжилтыг шинэчлэсэн болно.

“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ийн хүрээнд 2022.04.04-ний өдрөөс эхлэн хэлтсийн албан хаагчдад “Монгол бичиг”-ийн сургалтыг зохион байгуулж ажилчдын унших, бичих чадварыг дээшлүүлсэн.



“Улсын бүртгэгчийн 1 өдөр” сэдэвт 20 минутын телевизийн нэвтрүүлэг бэлтгэхээр бэлтгэл ажил хангагдсан байна.



Ажилчдын цайны цаг болон чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөхөөр үйлчилгээний заалны нэг хэсэгт номын булан нээж үр бүтээлтэй өнгөрөөж байна.

НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ:

Хэлтсийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд:

Батцэнгэл сумын улсын бүртгэгч Г.Нансалмаад сумын удирдлагуудтай хамтран ажилласны үндсэн дээр 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгуулсан.

Орхон Их сургуульд эрх зүйчээр суралцаж буй 4 албан хаагчдад сургалтын төлбөрт нь дэмжлэг үзүүлж мөнгөн тэтгэмж олгосон болно.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Аймгийн Засаг даргын хамтран ажиллах ажлын хүрээний асуудалд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 1970 онд ашиглалтанд орсон аймгийн Цагдаагийн газрын байрыг шилжүүлэн авахаар болсон.

Аймгийн ИТХ-аар Улсын бүртгэлийн хэлтэст 2000 м² газар олгохоор шийдвэрлэгдсэн. Аймгийн Засаг даргын захирамж гарч газрын гэрчилгээ олгогдсон.

Хамтын сангийн хуримтлалаас “Эх үрсийн баяр”-аар 36 албан хаагчийн хүүхдэд 720.000 төгрөгийн бэлэг тус тус өгч нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн.

БАЙГУУЛЛАГА ХАМТ ОЛНЫ ОРОЛЦОО:

“Илүүдэл жингүй-Эртч Монгол” аянд хэлтсийн хамт олон нэгдэж өглөөний дасгал алхалтад идэвхитэй оролцсон.



Эрдэнэбулган сумын Засаг даргын захирамжаар 2022 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр бүх нийтийн хог цэвэрлэгээний өдөр хэлтсийн албан хаагчид Булган уулын ойр орчим газрыг цэвэрлэж Цэцэрлэг хотоо хоггүй цэвэр орчныг бий болгоход хамт олноороо орууллаа.

Монгол улсын Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, төв суурин газрын ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх зорилгоор “Бүх нийтээр мод тарих хөдөлгөөн”, “Тэрбум мод” тарих үйл ажиллагаанд хамт олноороо идэвхитэй оролцлоо.



Дүгнэлт:

Тус хэлтэс 2022 онд Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга болон Аймгийн засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга

хэмжээг цаг тухай бүр хуулийн хүрээнд чанартай гүйцэтгэн ажиллаа. Хэлтсийн өдөр тутамын үйл ажиллагааг тасралтгүй шуухай иргэдэд чирэгдэлгүй хүргэн ажиллаж байна.

Бүртгэлийн явцад гарч буй зөрчлийг арилгах үүднээс мэдээллийн санд бүртгэл нь тусгагдаагүй, буруу регистрийн дугаар олгогдсон, өөр регистрийн дугаараар хурууны хээ өгсөн, хурууны хээ давхардсан, өмчлөгчийн мэдээлэл дутуу, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн **580** ширхэг хувийн хэргийг цахим санд тулган шалгаж мэдээлэл зөрүүтэй 35, иргэний улсын бүртгэлийн санд зөрүүтэй 106 зөрчлийг Хяналтын улсын байцаагчийн 1500, 1543 нэгдсэн дүгнэлтээр зөрчлийг арилган мэдээллийн санд засаж бүртгэлийг үнэн зөв болгон ажиллаа.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон өөрийн веб сайтаар хэлтсийн үйл ажиллагаагаа сурталчилан таниулснаар иргэд, албан байгууллага, аж ахуй нэгжүүд мэдээллийг цаг алдалгүй авч, бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцөл бүрдэж байна.

Бүртгэлийн хяналтын газраас хийсэн төлөвлөгөөт шалгалтанд 2021-2022 онд хийсэн хамруулан нийт зөрчил гарсаныг улсын бүртгэгч бүрээр танилцуулан зөрчлийг арилгах дахин давтан гаргахгүй байх гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээг авч ажиллаж байна. Бүртгэлд байнгын түүвэрчилсэн хяналтыг хийснээр зөрчлийг хурдан шуурхай илрүүлэх, түүнийг таслан зогсоох, дахин гаргахгүй байх, улсын бүртгэгч нараар гаргасан зөрчлийг нь тухай бүр арилгуулан ажиллаж байна.

Онлайн сургалтыг зохион байгуулснаар сумдын бүртгэгч нар цаг тухай бүр мэдээ мэдээллийг түргэн шуурхай авч ажлын хариуцлага сайжирсан.

Тоног төхөөрөмжийг бүрэн бүтэн байдлыг хангаж, тухай бүрд нь засвар үйлчилгээ хийж ажилласнаар хэлтсийн үйл ажиллагаанд хэвийн явагдаж байна.

Өргөдөл, гомдол гаргасан иргэн, хуулийн этгээдэд шийдвэрлэлтийн талаар утсаар мэдээлэл өгдөг болсноор төрийн үйлчилгээний шуурхай байдал хангагдаж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар санхүүгийн зөрчилгүй батлагдсан төсвийн хүрээнд өр авлага үүсгэхгүйгээр ажиллаж байна.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС